


**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ**

Үндэслэл, зорилго

Тус аймгийн нутгийн өөөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны бүх шатны байгууллагууд төрөөс баримтлах бодлого шийдвэрийг орон нутагт төлөвлөн хэрэгжүүлж, Ерөнхий сайдтай байгуулсан батламж, Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг бүрэн хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, үйл ажиллагааны үр дүнг үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлалаар гүйцэтгэн тайлагнаж байна.

2010 оныг “Хүүхдийн төлөө бүтээн байгуулалтын жил” болгон зарлаж, хүүхдийн сурч хөгжих, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох, төрөлх нутгийнхаа 70 жилийн ой угтсан ажлын бэлтгэлийг ханган, “Дуу хуурын өлгий Дундговь” урлаг соёлын өдрүүдийг нийслэл хотноо толилуулж, УБ-Мандалговийн хатуу хучилттай автозамын ажил эхэлсэн зэрэг улс, бүс, орон нутгийн шинж чанартай томоохон ажлуудыг хийсэн онцлог жил байлаа.



Үнэлгээний ажлын гол үр дүн:




Аймгийн тэргүүний малчдын зөвлөгөөнийг ХААН банкны салбартай хамтран зохион байгуулав. Тус зөвлөгөөнд байгалийн бэрхшээлд малаа хохиролгүй онд мэнд оруулсан 270 гаруй малчид, сумдын Засаг дарга, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд оролцож, тэд арга туршлагаасаа ярилцаж, хойшид авах арга хэмжээ, төрийн байгууллагын бодлогод саналаа тусгах, малгүй болсон нутаг усныхаа 1-2 малчныг малжуулах, өөрийн малаа түрээсээр маллуулах зэргээр амьдрал ахуйг нь дээшлүүлэхэд туслах санал санаачлага, зөвлөмж гаргалаа.

- ❖ БНСУ-ын ойн мэргэжилтнүүдийг урин ирүүлж Куяаны төгөл байгуулан 4 төрлийн 13 мянган ширхэг мод суулгац тарьж ургуулсан. Аймгийн хэмжээнд 2009 онд 19,7 га-д мод тарьж байсан бол 2010 онд 50,2 га талбайд 46 гаруй мод суулгацыг суулгаж, ургалт 82,1%-тай байсан.



- ❖ 2010 оныг “Хүүхдийн төлөө бүтээн байгуулалтын жил” болгон зарлаж, Мандалговь хотноо “Хүүхдийн парк” байгуулж, “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн бүх барилгуудын дээврийг шинэчлэн засварлаж, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, ард иргэдийн дэмжлэг тусалцаа, санал санаачилга, хүч оролцоотойгоор аймаг, сумын хэмжээнд гэр хороолол, гудамж талбайд 27 сүүдрэвч, 103 хүүхдийн тоглоомын талбай, сум бүрт хүүхдэд зориулсан номын сан, сүүний цех, хүүхдийн кафе, хүүхдийн номын болон хүнс, хувцас, тоглоомын төрөлжсөн дэлгүүртэй болж, жилийн ажилд улс, аймаг, орон нутаг, төсөл хөтөлбөр, иргэдийн хандив тусламжийн санхүүжилтээр нийт 2,5 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийснээс сургууль цэцэрлэгийн их засвар, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэхэд 2,2 тэрбум төгрөгийг зарцуулж, хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөлийг сайжруулаа.



- ❖ “Дуу хуурын өлгий-Дундговь” соёл урлагийн өдрүүдийг УБ хотноо зохион байгуулж, “Дундговь нутгийн өв соёл” үзэсгэлэнгээр аймгийн музейн 467 шилдэг үзмэр, сумдын 447 үзмэр гаргаж, концерт, жүжиг / мөн хүүхдийн концерт, жүжиг/ тоглож нийт 127 хүүхэд, 116 уран бүтээлч, ардын авьяастнууд оролцож аймгийн соёл урлагийг нийслэлийнхэнд таниулан сурталчилж, олон арван алдартнуудаараа бахархаж, залгамж тодруулах чухал ач холбогдолтой үйл явдал болсон.

- ❖ 30 гаруй судлаач, эрдэмтдээс бүрдсэн судалгааны баг 13 сумыг хамруулан ландшафтын төрөл бүрийн нөхцөлд доройтолд орсон бэлчээрийг сайжруулах технологи боловсруулж турших, урьд өмнө ургаж байсан ургамал нөмрөгийн төрөл зүйл тус бүрийг усалгаатай болон усалгаагүй аргаар туршиж ургуулах, ган болон хуурай нөхцөлд тэсвэртэй ургамлын сортуудыг гаднаас оруулж ирж нутагшуулах зэрэг бэлчээр сайжруулах туршилтыг практикт нэвтрүүлэх техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж ХХААХҮЯ-нд хүргүүлэв.

- ❖ Олон жил яригдсан УБ-Мандалговийн хатуу хучилттай авто замын ажил эхэлж, төвөөс 16,4 км замыг тавиад байна. Мандалговь-Олгойн говийн 11км ус дамжуулах шугам хоолойг 1,8 тэрбум төгрөгөөр шинэчилсэн.



- ❖ Өнгөрсөн өвөл, хаврын зуднаас сургамж авсан малчид өвөлжилтийн бэлтгэлээ базааж, 1373,0 тн өвс, 692,0 тн тэжээл, 3839,0 тн гар тэжээл бэлтгэсэн өмнөх жилүүдийн дунджаас 4-10 дахин илүү байгаа нь аймгийн Засаг даргын “Малчин түмэндээ илгээх захидал” малчин өрх бүрт хүрсэнтэй ч холбоотой.

- ❖ Төрийн албан хаагч бүр өргөсөн тангарагтаа үнэнч байж, авлига, хээл хахуультай тууштай тэмцэж, ёс зүйг мөрдөн, хуульд захирагдан, шударга ёсыг эрхэмлэн ажиллах нь Дундговь аймгийн нийт төрийн албан хаагчдын үндсэн үүрэг гэж үзэн “Шударга ёс, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг эрхэмлэн дээдлэгч аймаг” болох зорилтыг тавьж “Авлигатай тэмцэх олон улсын өдөр”-өөр ард иргэддээ хандан шударга ажиллахаа илэрхийлж, Мэдэгдэл гарган хэрэгжүүлж байна.



- ❖ Аймгийн Засаг дарга сум, төрийн байгууллагууд, харьяа агентлагуудынхаа ажилтай танилцаж, иргэдтэй уулзан төр засаг, аймаг орны бодлого шийдвэрийг танилцуулах, тэдний санал бодлыг сонсох, улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хүрээнд хийсэн хөрөнгө оруулалтын болон ЖДҮХС-аас авсан зээлийн хэрэгжилт, ашигт малтмалын ашиглалтын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцан үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт, үүрэг даалгавар өгч ажиллалаа.


- ❖ Аймгийн ЗДТГ, “Дэлхийн зөн” олон улсын байгууллага, ХААН банкны салбартай хамтран “Багийн хөгжилд – Багийн Засаг даргын үүрэг оролцоо” сэдэвт сургалт-семинарыг өнгөрсөн 5 сарын сүүлчээр аймгийн бүх сумдын багийн Засаг дарга нарыг оролцуулан зохион байгуулж багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудлууд, багийн Засаг

даргын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах арга зүй, нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг сурталчлах хэрэгжүүлэх, төрийн албаны стандарт, албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандарт мөрдөх, иргэдээс ирүүлсэн санал өргөдөл гомдлыг шийдвэрлэх зэрэг сэдвүүдээр ярилцаж, бүх багийн Засаг дарга нарт цаашид ажиллах чиглэл болгон 10 зүйл бүхий зөвлөмж чиглэл гарган өгч, бүрэн эрхээ тогтоомжуудын холбогдох багийн Засаг даргын ажлын багтаасан флашаар төв хөдөөгийн 4 багийн туршлагаас судалж ажлын арга туршлагаа хэрэгжүүлэхэд нь шаардлагатай хууль заалтуудаар гарын авлага материал, дэвтэр, шаардлагатай мэдээллүүдийг хангав. Энэ үеэр тэд Сайнцагаан сумын Засаг дарга нарын ажлын арга танилцах үзүүлэх сургуульд оролцож солилцлоо.



- ❖ “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-д 3 бүлэг, 28 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг улирлаар тооцон ажиллаж, бизнес эрхлэгчдийн сургалт зохион байгуулж бизнес төлөвлөгөө, төсөл бичих аргазүйгээр хангалаа. ЖДҮХС-ийн аймгийн дэд комиссын хурлаар 123 төсөл хэлэлцэж, 95 төслийг дэмжин банкинд уламжилж, 39 төсөлд 535,2 сая төгрөгийн зээл олгож, 115 ажлын байр шинээр бий болгов.

Зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн болон зохицуулалтын үнэлгээ



/Дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу/

Хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт

	Бүгд	Үүнээс		
		УИХ-ын тогтоол	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	117	1	104	12
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	172	1	154	17
Биелсэн /100%/	41	1	35	5
Хэрэгжих шатандаа	128		116	12
Үүнээс				
90%	87		78	9
70%	29		27	2
50%	11		10	1
30%	1		1	
Хугацаа болоогүй	3		3	
Биелэлтийн дүн /хувиар/	86,04%	100%	85.7%	88,24%

Үнэлгээний удирдлага, зохион байгуулалт, арга зүй:

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын 2010 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайланг ХШҮ-ний тасгийн даргын Засгийн газрын ХЭГ-аас зохион байгуулсан сургалтад оролцон ирж шинэ мэдээллээр хангагдсны дараагаас эхлэн үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалаар хийж гүйцэтгэлээ.

Мэдээлэл цуглуулах явцад “Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх”, “Үр дүнг танилцуулж, тайлагнах” сэдвүүдээр аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтсийн дарга нар, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд, сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, болон төрийн захиргааны албан тушаалд шинээр орсон албан хаагчдад зориулан сургалт, ярилцлага зохион байгуулсан.

Бодлогын зорилтуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхдээ аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нарын 3 удаагийн цуглаанд ХШҮ-ний тайлан гаргалтын явц байдлын талаарх мэдээллийг танилцуулан, харьяа агентлагуудтай хамтран ажиллах талаар арга зүй өгч, мэдээлэл ирүүлэх хугацаа, чанарт үнэлгээ өгч хяналт тавих үүргийг ХШҮ-ний тасагт аймгийн Тамгын газраас өгч ажиллав.

Түүнчлэн үнэлгээний явц, байдлыг албан байгууллагын дарга нарын шуурхай цуглаан, хэлтсийн дарга нарын хурал, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, анхаарах асуудлын талаар чиглэл, зөвлөмж өгсөн.

Үнэлгээг хэлтэс, агентлагуудаас ирүүлсэн мэдээлэл, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын жилийн ажлын тайлан, аймгийн Засаг даргаас Сайд нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээний биелэлт зэрэг баримт бичгийг үндэслэн хийлээ.

Түүнчлэн харьяа агентлагуудын ажил хариуцсан мэргэжилтнүүд болон аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдийн дарга, мэргэжилтнүүдтэй биечлэн уулзан ярилцаж, цуглуулсан мэдээллээ баримтжуулан асууж лавлах байдлаар тайлангаа бэлтгэсэн болно.

Тайлангийн бүтэц:

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн тайлан 5 хэсгээс бүрдэнэ. Тайлангийн 1-р хэсэгт бодлогын зорилтын хэрэгжилтийн үнэлгээ, тайлангийн 2-р хэсэгт бодлогын хэрэгжилтийн зохиуулалтын үнэлгээ, 3-р хэсэгт байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ, 4-р хэсэгт байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ, 5-р хэсэгт үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээг танилцуулав./Хавсралтаар хүргүүлэв./

Тайлангийн төгсгөлд үнэлгээний ажлын ерөнхий дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх гол гол арга хэмжээ, санал зөвлөмжийг тусгалаа.

Дүгнэлт:

Юуны өмнө ЗГХЭГ-аас шинэ тутам зохион байгуулагдсан аймгуудын ТЗУХ-ийн хяналт шинжилгээ үнэлгээний тасгийн дарга, мэргэжилтнүүдийн хяналт шинжилгээ үнэлгээ хийх чадавхийг дээшлүүлж бэхжүүлэх талаар шат дараатай сургалт семинар зохион байгуулж, гарын авлага, ном товхимолоор хангаж байгаа явдал нь үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулж байна.

Тайлангийн хугацаанд Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийг бүрэн хэрэгжүүлэхэд дараах ажлуудыг санаачлан зохион байгуулж үр дүнд хүрсэн байна. Мөн дутагдалтай асуудлууд байлаа.

Орон нутгийн төсвийн дүнгээр орлогын төлөвлөгөөг 106,7 хувиар биелүүлж төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ханган жилийн нийт төсвийн зарлагын 77,3 хувийг өөрийн орлогоороо санхүүжүүлж ажиллсан нь өнгөрсөн онтой харьцуулахад 7,3 хувь өссөн байна.

Өнгөрсөн онд аймгийн орон нутгийн төсвийн нийт зарлага 3920691,4 мянган төгрөгт хүрч 15 сум, шууд харьцдаг 51 байгууллагыг санхүүжүүлж ажиллав.

Өнгөрсөн оны орон нутгийн төсвийн хүрэлцээ тун хүнд байсныг ЗГ-аас авч явуулсан удаа дараагийн арга хэмжээний дүнд 61,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь ихээхэн тус нэмэр болсон байна.

Хууль тогтоомж, шийдвэрийг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлыг тогтмолжуулан, иргэдийн эрх зүйн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлж, хуулийн байгууллагуудын хөрөнгө оруулалт нэмэгдэж, гэмт хэргийн тоо, холбогсодын тоо өнгөрсөн оноос буурсан зэрэг ажлын үр дүнгээрээ аймгуудаас тэргүүн байранд, мөн “Эрх зүйн туслалцааны төв” нь хүний эрхийн өдрийг угтаж зохион байгуулсан уралдаанд тэргүүн байранд тус тус шалгарч эрх зүйн лавлагаа, мэдээлэл бүхий номын сангаар шагнууллаа.

Хүн амын эрүүл мэнд, хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, хүний хөгжлийг дэмжин иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулахад үйл ажиллагаагаа хандуулж ажилласан байна.

Эхийн эндэгдэл гаргалгүй ажиллаж, хүн амын эрүүл мэнд хамгаалах, урьдчилан сэргийлэх талаарх сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэн тогтмолжуулж, 3 сумын эмнэлгийн барилга шинээр барьж, 2 эмнэлгийн барилгад их засвар хийж, эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн, 0-1 насны хүүхдийн эндэгдэл өмнөх оноос буурч, дархлаажуулалтын хамралтыг 99-100 хувьд хүргэн, тарилгатай халдварт өвчин гараагүй болно.

Жил бүр зохион байгуулдаг “Дундговь-түншлэл-2010” арга хэмжээнд оролцсон аж ахуйн нэгж, иргэдийн тоо өнгөрсөн оныхоос 125-аар буюу 2 дахин, борлуулалт 35,4 сая төгрөгөөр буюу 64 хувиар тус тус өссөн байна.

Мянганы хөгжлийн зорилтууд, бүс нутгийн болон Монгол улсын хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрт Дундговь аймагтай холбоотой төлөвлөгдсөн томоохон бүтээн байгуулалтын ажил болох Мандалговь-Өмнөговь-Тавантолгой-Оюултолгойн 2 хэлхээтэй 220 кВт-ын 429 км цахилгаан дамжуулах шугам, дэд станцын 160,0 тэрбум төгрөгийн ажлын судалгаа, зураг, төсөв хийгдсэн, 2011 оноос барилга байгууламж барьж эхэлнэ.

Эрх хувиараа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 254 иргэнд 778 сая төгрөгийн жижиг зээл олгож, 316 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, үйлдвэрлэл үйлчилгээний тоог 10 хувиар нэмэгдүүлсэн, мэргэжил олгох сургалтанд 539 ажилгүй иргэнийг хамруулж, 68,3 хувь байнгын ажлын байраар хангагдсан хүмүүсийн 60-65 хувь нь цөөн малтай буюу малгүй болсон иргэдийг хамруулсан байна.

Аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх, тэднийг сургах, мэдлэг чадвар бий болгох талаар санаачлагатай ажиллаж, аймагт нэн шаардлагатай байгаа мэргэжлээр суралцах иргэдийн сургалтын зардалд нь аймаг, сумаас санхүүгийн зохих тусламж үзүүлэх, сургууль төгсөгчидтэй гэрээ байгуулж, ажиллаж амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, албан хаагчдын ажлын үр дүнг нь харгалзан урамшуулал, тэтгэмж олгох, мэдлэг боловсролын түвшингээ ахиулах, мэргэшил дээшлүүлэх боломж нөхцлөөр хангах, ажлын байранд дахь сургалт семинарыг нэгдсэн график төлөвлөгөөтэй явуулсны үр дүнд аймгийн хэмжээнд төрийн захиргааны удирдлага, эрх зүйч, нягтлан бодогч, зарим мэргэжлийн багш нарын хэрэгцээ үндсэндээ хангагдсан. Гэвч хүний эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон инженерийн чиглэлийн мэргэжилтний хэрэгцээ бүрэн хангагдаж чадахгүй байна.

Ер нь орон нутгийн түвшинд хүний нөөцийн төлөвлөлтийг хангалттай сайн боловсруулж сураагүй, төлөвлөлтийг дунд сургуулийн элсэлтийн шалгалттай нягт уялдуулж чадахгүй байна.

Түүнчлэн БСШУЯам элсэлтийн шалгалтын захиалгыг орон нутгийн санал захиалгын дагуу авч, элсэлтийн хуваарийг тэр онцлогт нь тохируулж ирүүлэхгүй байна. Үүнээс шалтгаалж жил бүр орон нутагт шаардлагагүй олон тооны мэргэжлээр элсэлт авч тэр хэмжээгээр олон мэргэжилтэн сургууль төгсөж орон нутагт ирдэг боловч аймаг, сумдад ажиллах ажлын байр байхгүй учир эргээд нийслэл хот болон бусад аймаг хот руу шилжиж байгаагаас мэргэжилтэй боловсон хүчний хангалтад нааштай өөрчлөлт гарахгүй, тэдний тогтвор суурьшил төдийлөн сайжрахгүй байна.

Манай аймгийн хувьд өнгөрсөн өвөл хавар цас их унаж, өмнөх жилүүдээс илүү хүйтэрч, зуд нүүрлэн гамшгийн хэмжээнд хүрч, малчдын амьжиргаа, мал аж ахуйд ихээхэн хохирол учирч, энэхүү

гамшгийн улмаас нийт мал сүргийнхээ 40,9 хувь буюу 878,2 мянган малаа хорогдуулж, малчин өрхийн 68,1 хувь буюу 4857 нь малаа хорогдуулсан үүнээс 344 малчин огт малгүй болж, ажилгүйдлийн түвшин өмнөх оноос 1.5%-иар нэмэгдэж, 3.9 %-д хүрсэн.

Ган, зуд, байгалийн гамшгийн улмаас мал сүрэг ихээр хорогдсноос нийт мал сүрэгт нутгийн шилмэл болон цэвэр эрлийз /цөм сүрэг/ малын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилт биелсэнгүй. Мөн хөрөнгө мөнгөний дутагдлаас мах боловсруулах болон ноос угаах үйлдвэр байгуулах, Мандалговь хотын ерөнхий төлөвлөгөө хийх, орон нутгаас шалтгаалахгүй нөхцөл байдлаас 8 сумыг шилэн кабельд холбох зэрэг томоохон төлөвлөгдсөн асуудлууд тасарсан байна

Бид 2011 онд удаашралтай байгаа болон тасарч болзошгүй бодлогын зорилтыг эрчимжүүлэн хэрэгжүүлэхэд санаачлагатай ажиллаж, “Цахим шуудан”, “Ногоон хөгжил Дундговь” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Дундговийнхон оюунтай толгойгоороо хөгжих, тэмээн сүргийг “төмөр сүргийн бодлого”-оор өсгөх, хөмүүл хэмээх шимт ургамлыг тарималжуулж түүнийгээ боловсруулан улсдаа төдийгүй гадаад зах зээлд борлуулах, гадаад улс орнуудтай тогтоосон харилцааг гэрээний үндсэн дээр өргөжүүлэх, аялал жуулчлалыг нэмэгдүүлж хөрөнгө оруулалтыг хөгжилд чиглүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бодитой бууруулах зэрэг зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

- Аймгуудын тайлангаас харахад Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцохдоо аймаг бүр харилцан адилгүй дүгнэж байна, Тиймээс хөтөлбөр хэрэгжсэнээс хойших буюу өссөн дүнгээр эсвэл тухайн жилийн хэрэгжилтийн байдлаар тооцох, ирүүлэх талаар нэг мөр ойлголттой болох,
- Үндэсний хэмжээнд тухайлбал нийгмийн салбарт маш олон хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн нь хүний хөгжлийг хангахад анхаарсан сайшаалтай бодлого гэж үздэг. Гэвч орон нутагт хөрөнгийн дутагдлаас бүрэн хэрэгжих боломжгүй байгаад дүгнэлт хийж, орон нутагт хэрэгжүүлэхэд төсөв хөрөнгийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, үр дүнг тооцох, үнэлгээ хийх ажлыг чанаржуулах шаардлагатай.
- Төсвийн тухай хуульд орон нутгийн бие даасан байдлыг хангах, төсөв санхүүгийн эрх мэдлийг өргөтгөх асуудлыг тодорхой тусгаж хэрэгжүүлэх
- “ХӨГЖЛИЙГ ХӨДӨӨД” хүргэх бодлого зорилт хэрэгжүүлж, орон нутгийн удирдлагын эрх хэмжээг нэмэгдүүлэх, хөдөө орон нутаг, ялангуяа говийн бүсээс гадаад оронд өндөр мэргэжилтэй боловсон хүчнийг гэрээгээр бэлтгэж мэдлэгт суурилсан хөгжлийг бий болгох
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад үдийн цай өгч, улмаар үдийн хоол болгох ажлыг орон нутагт хэрэгжүүлж байна. Иймээс сургуулиудыг үдийн хоолны стандартын газартай болгох ажлыг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар шийдэж хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Сумдад нийгмийн хэв журам сахиулах үүрэгтэй ажилладаг олон нийтийн байцаагчийн урамшууллын зардлыг төсөвт тусгаж шийдвэрлэх
- Мэдээллийн чанарыг сайжруулах, түүнийг нэгтгэн зангидах, өөрчлөлтийн чиг хандлагыг харуулсан баялаг мэдээллийг бүх түвшинд бий болгох хэрэгтэй байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.ЧАНДМАНЬ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Л.ЦЭВЭЭНРАВДАН